


Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын археологийн судалгаа

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь эртний нийслэл Хархорум хотын туурийг эрж олох зорилготой 1889 онд Оросын эзэн хааны Газарзүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбараас томлигдсон эрдэмтэн Н.М.Ядринцев удирдсан хээрийн шинжилгээний анги Орхон голын хөндийд ажиллан Эрдэнэ Зуу хийдийн дэргэд буй эртний хотын туурь, Цайдам нуурын дэргэдэх Түргийн үеийн язгууртны бичигт хөшөө зэрэг дурсгалуудыг илрүүлэн олсон цагаас Монгол Улсад эртний судлал буюу археологийн судалгаа эхэлсэн түүхтэй. Түүх, соёлын дурсгалыг 1889 оноос өнөөг хүртэл 120 гаруй жилийн хугацаанд энэхүү бүс нутгийг археологийн малтлагаар судлан шинжлэх ажил тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн байдлаас үл шалтгаалан судалгаа тогтмол хийгдэж байсан байдаг. Дээрх судалгааны өвөрмөц тал нь гагцхүү гадаад орны эрдэмтэд дагнан гүйцэтгэдэг байжээ.



МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН “ХАРХОРУМ” ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

ЮНЕСКО-ийн ивээл дор 1995-1996 онд зохиогдсон Хар Хорум хотын туурийг хадгалан хамгаалах шинжилгээний анги нь Монголын эртний нийслэлийн судалгаанд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Монгол-Японы судлаачид хамтран гүйцэтгэсэн энэхүү төсөл нь эртний нийслэлийн дэвсгэр талбайн хотгор гүдгэрийн болон археологийн нарийвчилсан дэвсгэр зураг үйлдэж, хамгаалалтын бус тогтоон. Түүнчлэн тус шинжилгээний анги нь Хар Хорум хотын ойр орчимд буй соёл түүхийн холбоо бүхий өөр бусад хот хэрмийн үлдэгдлийг хамруулан судалсны тоонд Мэлхийт буюу Тогос орд, Захын булаг, Баянголын балгас, Хөгшин Орхоны дөрвөлжин газар, Хар бондгор зэрэг дурсгалыг дурдах хэрэгтэй.

Монгол-Японы хамтарсан "Бичээс" төслийн шинжилгээний ангийнхан 1996-1998 онд зохион байгуулсан ажлын явцдаа Хархорум хотын туурь, Эрдэнэ Зуу хийдийн ойр орчимд орших монгол, хятад, перс бичигтэй хөшөөдийг илрүүлэн судалсан.

Монгол болоод Герман улсын ерөнхийлөгчдийн ивээл дор 1999 оноос уйл ажиллагаагаа эхэлсэн Монгол-Германы эрдэмтдийн хамтарсан Хар Хорум хотыг судлах шинжилгээний анги нь уг хотын гол гол хэсгүүдэд дахин шинээр нарийн нямбай малтлагын ажлыг хийж эхэлсэн бөгөөд уг хотын хотгор гүдгэрийн нарийвчилсан зургийг үйлдэж, малтах газартаа геофизикийн судалгаа хийж, газрын дор чухам юу байгааг урьдчилан тандаж мэдэх, олдворуудын насыг байгалийн шинжлэлийн дэвшилтэт аргуудаар тодорхойлох зэрэг боловсронгуй арга зүйг хэрэглэн дурсгалыг бүх талбайгаар нь малтах, илрүүлж гаргасан зүйлсийг маш нарийн нямбай бүртгэн авч судлах, хөрсний дороос илэрсэн эртний байгууламжуудыг анхны дур төрхөөр нь хадгалж үлдээх, улмаар бэхжүүлэн сэргээж нийтэд сонирхуулах үзмэр болгон ашиглах зорилт тавин ажиллаж байна. 2000 болон 2001 оны малтлага судалгааны явцад эрт цагт барилгын хэрэглэгдэхүүн үйлдвэрлэж байсан 4 их зуухны ор үлдэгдэл, Эрдэнэ зуу хийд байгуулагдахаас өмнөх үед холбогдох бурхны шашны олон хөрөг баримлын үлдэгдэл, хотын төв дэх гудамжны уулзвар орчмын малтлагаас эртний чулуу дэвсмэл гудамж, байшин барилгыг халаах ханзын үлдэгдэл, хотын хөгжлийн олон үеийг харуулах хоорондоо зааг ялгаа бүхий соёлт давхаргууд, 300 шахам зоос, түүний дотор монголын дөрвөлжин үсэгтэй зооснууд, 1372 оны үед холбогдох Аюушридар буюу Билэгт хааны үеийн Сангийн яамны сайдын тамга зэрэг олон чухал олдворыг илрүүлж олоод байна.

Хайгуул судалгаа(2018, 2019 он).

Хархорин сумын нутагт орших Хархорум хотын хамрагдах бүс нутгийн болон Орхон голын савд археологи, геомагнетикийн нарийвчилсан хайгуул судалгаа явуулж, үйлдвэрлэл эрхэлж байсан ул мөр, оршин суугчдын оршуулга зэрэг бусад холбоотой дурсгалуудыг тогтоон илрүүлэх, цаашдын судалгааны урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Орхон голын савд уртраг, өргөрөгийн дагуу 1 км² талбайд хуваасан, латин үсэг болон тоогоор системтэй дугаарласан, нийт 40 км² талбайд, 11 хүн хоорондоо 20 м зайтай явганаар самнах буюу шугаман хайгуулын арга зүйгээр явуулав. *Монголын талаас:* ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор Ц.Цэрэндорж удирдагчаар, хээрийн шинжилгээний ангийг Л.Мөнхбаяр,

Герман талаас: ХБНГУ-ын Бонны Их Сургуулийн Нэн эртний болон эртний түүхийн археологийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор Ян Бемманн, доктор Сусанне Рейхерт, мөн Дэлхийн Өв-Орхоны хөндийн Соёлын Дурсгалт Газрын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан ажилтан Н.Гомбожав, Хархорум музейн ЭША Ж. Цамбагарав, МУИС, Ховд ИС, мэргэжлийн ангийн Б.Амгаланбаатар, Б.Алтангадас, У.Очирпүрэв, Ц.Буян-Орших нарын болон ХБНГУ-ын Бонны Их Сургуулийн 3 оюутан, 2 жолоочийн бүрэлдэхүүнтэй ажиллан Хархорум хот болон Орхон голын савд явуулсан археологийн хайгуул судалгааны үр дүнд нийт 232 дурсгал (site) 2018 онд бүртгэв.



Зураг 3. Хайгуул судалгааны 1 км² -д хуваасан талбай болон ажлын явц.

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН “ОРХОН” ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН МАЛТЛАГА СУДАЛГАА

Монгол-Германы Орхон экспедици 2007-2019: 1999 оноос эхлэн Монголд үйл ажиллагаагаа амжилттай явуулсан Монгол-Германы “Хархорум” экспедици (MDKE) цаашид Монгол-Германы “Орхон” экспедици (MONDOREX) болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж судалгаа шинжилгээний ажлын цар хүрээгээ тэлсэн билээ.

Монголын талаас: Монголын талын удирдагч, МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхмийн профессор, доктор У.Эрдэнэбат, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Т.Батбаяр, төслийн ажилтан, магистр Ц.Бямба-Эрдэнэ, ХБНГУ-ын талаас: Германы талын удирдагч, Германы Археологийн хүрээлэнгийн (KAAK, DAI) Европын бус Соёлын Археологийн Комиссийн археологич, доктор К.Франкен, докторант Х.Рооланд нар болон туслах ажилтнаар ХБНГУ-ын Бонны Их сургууль, МУИС-ийн мэргэжлийн ангийн оюутнууд оролцон ажиллав.

Монгол-Германы хамтарсан “Орхон” экспедици Хар Балгасын их хэрмийн цитадель дээр гол судалгаагаа төвлөрүүлэн ажилласны зэрэгцээ 2018 оны 8 сарын 1-нээс 8 сарын 21-нд хотын их хэрэмт байгууламжаас урагш 3,9 км зайд, төв гудамжны төгсгөл хэсгийн зүүн талд байрлах нэгэн овгор шороон байгууламжийг өмнөх жил сонгон авч шинээр малтлага судалгааны ажил эхлүүлж байсныг үргэлжлүүлэв. Энэхүү байгууламж нь гадуураа шороон хэрэмтэй ба дотроо хэд хэдэн овгор шороон барилгын туурьтай. Энэхүү хэсгийг хотын дэвсгэр талбайд хийсэн малтлагын баримтжуулалтын дарааллын дагуу НВ 4 гэж нэрлэн туурийг 24x24 метр урт 2 м өргөнтэй 96 ам дөрвөлжин талбайд малталт судалгаа хийсэн бөгөөд энэхүү судалгаагаар эртний барилгын суурь

довжооны үлдэгдэл илэрч олдсон байна. Мөн НВ 4 хэсгийн малтлагаар вааран сав суулганы хагархай, тамга тэмдэгтэй дээврийн ваар зэрэг олдворууд олдсон байна.

Хар Балгасын цайзат хэрмийн баруун урд буланд орших цитадельд (шороон байгууламж) дээр 5 жилийн турш малтлага судалгаа хийж 2018 онд явуулсан археологийн малтлага судалгаагаар боржин чулуун хавтанг зургаан тал гарган 12 үеэр өрж доторлосон худаг илрүүлэв. Уг худаг нь 13 метр орчим гүнтэй байсан ба дотроос нь шавар ваар, хятад бичигтэй, төмөр хэлтэй, хүрэл хонх, хэд хэдэн ваар, ургамлын дүрсээр хээлсэн чий будагтай модон шонгийн хугархай хоёр ширхэг олдсон нь нүүдэлчдийн гар урлал өндөр түвшинд хөгжиж байсан хийгээд гадаад харилцааг илэрхийлэх гэрч баримт юм.



Зураг 4. Хар балгас шороон хэрэмний баруун урд хэсэг цитаделийн малтлага.



Зураг 5. Хар балгасын худаг дотроос илэрсэн олдворууд.

Хар Балгасын их хэрмийн дотор талд орших харуулын цонж хэмээн нэрлэдэг 14 метр орчим өндөр шороон байгууламжын зүүн талын хэсэгт археологий сорилтын малтлага, мөн төв гудамжны төгсгөл хэсэгт хайгуул болон малтлага судалгааны ажил 2019 онд хийв.



Зураг 5. Хар балгас харуулын цонж 2019 оны сорилтын малтлага.

МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН “УМАРД МОНГОЛЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУДАЛГАА”
ТӨСЛИЙН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН НУТАГ ОРХОН-1, ОРХОН-7,
МОЙЛТЫН АМНЫ ХУУЧИН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫН СУДАЛГАА

ОХУ-ын Новосибирскийн Археологи, Антропологи, Угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран “Умард Монголын палеолитын судалгаа” эрдэм шинжилгээний төслийг 2002 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Энэхүү хамтарсан төслийн хүрээнд Монгол орны Хангайн бүс нутгаас хуучин чулуун зэвсгийн үеийн соёлт давхарга бүхий дурсгалт газруудад болон шинээр илрүүлсэн дурсгалуудыг судалж хуучин чулуун зэвсгийн дунд үеэс дээд үед хэрхэн шилжсэн асуудлыг тодруулах, тухайн үеийн эртний хүний ул мөрийг хайх, хүрээлэн буй орчинг цогц байдлаар судлах, дэлхий нийтийн энэ үеийн түүхийн судалгааг шинэ баримт хэрэглэгдэхүүнээр баяжуулахад чиглэсэн судалгааг хийж байна.

Хархорин сумын нутаг Орхон-1, Орхон-7 болон Мойлтын амны чулуун зэвсгийн сууринд 30 жилийн өмнө хийгдсэн малтлагын соёлт давхаргуудын хөрсний дээжийг OSL

/тухайн хөрсний хамгийн сүүлд нарны дулаан шингээсэн арга/ аргаар тогтоолгон эдгээр дурсгалуудын үнэмлэхүй он цагийг баттай тогтоолгон, давхаргуудаас гарсан чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн аргыг тодруулахад чиглэгдэж байгаа юм.

Энэхүү судалгаанд Монголын талаас: Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн тэргүүлэх ажилтан, доктор, профессор Б.Гүнчинсүрэн удирдан, эрдэм шинжилгээний ажилтнаар доктор Д.Базаргүр болон туслах ажилтанаар Дэлхийн Өв-Орхоны хөндийн Соёлын Дурсгалт Газрын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан ажилтан Н.Гомбожав, мэргэжлийн ангийн н.Хатанбаатар, П.Очирбаатар нар, болон туслах ажилтанууд,

Оросын талаас: ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, Угсаатны зүйн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, доктор Е.П.Рыбин удирдан, эрдэм шинжилгээний ажилтнаар А.М.Хаценович, Д.В.Марченко, А.М.Клементьев, С.А.Когай, Р.А.Шелепаев, А.Ю.Попов, Н.А.Кравцова, Т.А.Шевченко нарын бүрэлдэхүүнтэй 2018, 2019 онд ажиллав.



Зураг 6. Мойлтын амны хуучин чулуун зэвсгийн үеийн суурингийн малтлага, гар зураг(2018 он).



Зураг 7. Орхон-1 хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгалт газрын малтлага, гар зураг(2018 он).



Зураг 8. Орхон-7 хуучин чулуун зэвсгийн үеийн суурингийн дурсгалт газар болон сорилтын малтлага(2019 он).